



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035

Утас/Факс: (976-11) 32-71-99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2023.01.06 № 03/132
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны ажил дүгнэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1592 дугаар захирамжийн дагуу 2023 оны үйл ажиллагаанд анхаарч ажиллах зөвлөмжийг хавсралтаар хүргүүлэв.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жилээр Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



И.БААТАРХҮҮ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын
2022 оны үйл ажиллагааны үр дүнг
үнэлэх ажил зохион байгуулсан тухай

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” А/1504 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний ажлын хэсгээс тус байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд “Хангалттай” гэсэн үнэлгээ өгч, танай байгууллагын зүгээс 2023 оны үйл ажиллагаандаа анхааран ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан Нээлттэй мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулах;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний агуулгыг оновчтой тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэхэд анхаарах;
- “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд туссан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа үг үсэг, утга найруулгад онцгой анхаарч албан бус товчилсон үг хэрэглэхгүй, тоон мэдээ мэдээллийн үнэн бодитой эсэхэд анхаарах;
- “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээ хийх;
- “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган үнэлгээний дүнг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчдад хүргүүлж, үр дүнг тооцон ажиллах;
- Захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг боловсруулах, батлуулах, зохион бүрдүүлэхдээ MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021 стандартыг тогтмол мөрдөн ажиллах;
- Байгууллагад ирсэн бичгийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллах;


111020000313

- Байгууллагаас явуулсан бичигт хавсралтын тухай тэмдэглэлийг тогтмол хийж, баримт боловсруулалт, eDoc систем ашиглалтыг сайжруулах;
- Захирамжлалын баримт бичгийг нөхөж гаргах, засварлах, байгууллагын даргын гарын үсгээр баталгаажуулахгүй баримт бичгийг хэрэгт авах асуудлыг хатуу хориглох;
- Захирамжлалын баримт бичигт боловсруулсан, хянасан тухай бүрдлийг тогтмол хийлгэж, баталгаажуулах, хавсралтыг стандартын дагуу үйлдэх;
- Боловсруулан баталж буй захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэл, агуулга, найруулга зүйд анхаарах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлсэн ажлын тайланг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад тайлагнаж, ажиллах;

Энэхүү зөвлөмжийн дагуу дутагдал зөрчлийг арилгаж, гүйцэтгэл сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэн баримтжуулж, илтгэх хуудсаар 2023 оны 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж ажиллана уу.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ГАНТУЛГА



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУНГАЛАГ